



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/331

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлж, ашиглах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Эрхийн мэдээллийн санг бүрдүүлж, хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах, хянах, аж байдлыг сайжруулах бодлого, үйл ажиллагаанд ашиглахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/, аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтэст үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/ нарт даалгасугай.



Н.НОМТОЙБАЯР

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2016 оны 12 дүгээр сарын 26-ны
өдрийн 4/331 тоот тушаалын нэгдүгээр
хавсралт

ХҮҮХДИЙН ЭРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЖ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хүүхдийн эрхийн мэдээллийн санг /цаашид мэдээллийн сан гэх/ бүрдүүлэх, удирдах, ашиглах, мэдээллийг шинэчлэх, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мэдээллийн санг бүрдүүлж, ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалтай холбоотой үйл ажиллагаанд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, журмыг удирдлага болгоно.

1.3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.1-т заасан үүргийг биелүүлэхэд гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

Хоёр. Мэдээллийн санг бүрдүүлэх

2.1. Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хэвийн ажиллуулах, шинэчлэх үүргийг гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээнэ.

2.2. Мэдээллийн сан нь үндэсний статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу тогтоосон дараах мэдээллийн баазаас бүрдэнэ.

2.2.1. Хүүхэд хамгааллын статистикийн үзүүлэлтийн мэдээллийн сан;

2.2.2. Хүүхдийн халамж, асрамж, хамгааллын үйлчилгээ эрхлэгч болон үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн мэдээллийн сан;

2.2.3. Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан;

2.2.4. Хамтарсан багийн үйлчилгээний бүртгэлийн мэдээллийн сан;

2.2.5. Хурдан морь уралдаанч хүүхдийн бүртгэлийн мэдээллийн сан;

2.2.6. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны мэдээллийн сан;

2.2.7. Хүүхдийн тусламжийн утас, үйлчилгээний мэдээллийн сан;

2.2.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, нийгмийн үйлчилгээний мэдээллийн сан;

2.2.9. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч, үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн мэдээллийн сан;

2.2.10. Хүүхдийн хөгжил, амралт, чөлөөт цагт чиглэсэн үйлчилгээний байгууллагын төрөл, түүний хөтөлбөр, арга зүйн мэдээллийн сан;

2.2.11. Хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн мэдээллийн сан;

2.2.12. Хүүхдийн эрх хамгаалал, хөгжил оролцооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон төрийн бус байгууллагуудын мэдээллийн сан;

2.2.13. Бусад;

Гурав. Мэдээллийн санг ашиглах, шинэчлэх

3.1. Мэдээллийн сангийн мэдээллийг хүүхдийн эрхийн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, түүнийг хянах, бодлого боловсруулах үйл ажиллагаанд төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд ашиглана.

3.2. Мэдээллийн сангийн нийтэд ил тод байх тоон мэдээллийг гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон Монгол Улсын статистик мэдээллийн нэгдсэн сангийн цахим хуудсанд байршуулна.

3.3. Энэ журмын 3.2-т заасан нийтэд ил тод байх мэдээлэл гэдэгт байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой мэдээллээс бусад мэдээллийг ойлгоно.

3.4. Мэдээллийн сангийн тоон үзүүлэлтийг хагас жил тутам шинэчлэх ба хүүхдийн эрхийн зөрчлийн тохиолдол, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг тухай бүр шинэчилнэ.

3.5. Мэдээллийн сангийн технологийн шинэчлэлийг гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

Дөрөв. Мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, нууцлал

4.1. "Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрийн газар нь мэдээллийг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ашиглах болон түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах чиглэлээр гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний орон нутгийн байгууллагын албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулж, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.

4.2. Мэдээллийн сан ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалыг хангах үйл ажиллагаа нь Төрийн нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Засгийн газрын 2013 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”, мэдээллийн аюулгүй байдал, технологийн талаарх Монгол Улсын холбогдох стандартад нийцсэн байна.

Тав. Бусад

5.1. Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагаанд санаатай болон санамсаргүй хэлбэрээр хохирол учруулах, хадгалагдаж байгаа мэдээ, баримтыг зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, устгах, байгууллага, хувь хүний нууцыг задруулах, мэдээ, тоо, баримтыг хууль бусаар ашиглахыг хориглоно.

5.2. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, иргэнд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----